

**“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
2025-04-21-НИЙ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025-04-21

Улаанбаатар хот

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурал 2025-04-21-ний 11:00 цагт компанийн хурлын танхимд болов.

Ирц: **95,69%**

Тооллогын комиссын гишүүн С.Баясах: Компанийн нийт хувьцааны 95,69%-ийг төлөөлсөн 17 хувьцаа эзэмшигчид оролцож буй тул хурал хүчин төгөлдөр болох тухай тогтоол № 1-ийг уншиж танилцуулав.

Хурлын дарга Ё.Энхтөр: Хурлын ирц бүрдсэн тул хурлаа эхлүүлье. Хурлаар дараахь 3 асуудлыг хэлэлцэнэ.

- Компанийн үйл ажиллагааны 2024 оны гүйцэтгэл, 2025 оны зорилтын тухай
- Компанийн 2024 оны санхүүгийн тайланд Аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт
- Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсөв батлах

Мөн хурлын дэгийг танилцуулав.

Ё.Энхтөр: Дэгийн дагуу 1-р асуудлыг ТУЗ-ийн дарга Ц.Зоригт танилцуулна.

Ц.Зоригт: Та бүхэнд тараагдсан материалд 2024 оны тайлан байгаа тул товч танилцуулъя. Тус компани үнэт цаасны 52 компанид харьяалалтай 891 хувьцаа эзэмшигчтэй байна. Компанийн зах зээлийн үнэлгээ: 15,7 тэрбум төгрөг. Жилийн дундаж үнээр нэгж хувьцааны үнэ: 24 600₮-56 300 төгрөгний хооронд хэлбэлзэж байна. Нийт хувьцааны 95,4% нь 8 хувьцаа эзэмшигчид төвлөрсөн байна. Компанийн 2023 онд нэгж хувьцаанд 1750 төгрөгний ноогдол ашиг хуваарилсан бол 2024 оны ажлын үр дүнгээр 2000 ₮ хуваариалахаар шийдвэр гарсан байна. СЗХ-ны тогтоолын дагуу, “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтээр бүртгэлтэй 108 компаниас 43-т жагссан байна.

Компанийн 50 гаруй жилийн ажлын үр дүнг үнэлж, МУЗГ-аас компанийн хамт олныг 2024 онд “АЛТАНГАДАС” одонгоор шагнасан.

Борлуулалтын талаар: 2024 онд 52170 м2 буюу 6,87 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 23,2%-аар өссөн. 1170,1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллав. Компанийн фэйсбүүк дагагчдын тоо өнгөрсөн оныхоос 10% өссөн. Баянзүрх дүүрэгт шинэ борлуулалтын цэг нээсэн. ОХУ-ын Улан-Уд-ийн “Буриад ЭКСПО” зэрэг үзэсгэлэнд амжилттай оролцсон. Жилдээ 4100 ширхэг буюу 143 сая ₮-ийн сүлжмэл борлуулав.

Үйлдвэрлэлийн талаар: 52068 м2 хивс үйлдвэрлэсэн. 641,7 тн ноос худалдан авсан. Нарийн ээрэх цехэд 115,3 тн ноос боловсруулж 77,8 тн ээрмэл ээрлээ. Аппарат ээрэх цехэд 24/2 ээрмэл 61,7

кг; 12/1 номерын ээрмэл 1871,8 кг; 24/1 номерын ээрмэл 14 кг-ыг тус тус үйлдвэрлэв. Будах цехэд 88590 кг ээрмэл будлаа. Хялгас ялгах цехэд 6711 кг холионоос 2425 кг хялгасыг ялгасан ноос буюу 36%-ийн гарцтай байв. Оёдлын цехэд эсгий гудас 26 ширхэг, хивсэн углааш 200 хос, машины иж бүрдэл хивс 146 ширхгийг тус тус үйлдвэрлэв.

Инженерийн байгууламжийн хэсэг компанийн барилгын чердак, түнелийг цэвэрлэж, шаардлагатай холболт, засвар үйлчилгээг хийж компанийн найдвартай ажиллах нөхцлийг бүрдүүлж ажиллалаа. 95,0 сая төгрөгийн эрчим хүчний бодит хэмнэлт гаргав.

Хүний нөөц:

- Ажиллагсдын тогтвор суурьшил 30,1%, дундаж нас 46 байна.
- Нийт ажиллагсдыг эрүүл мэндийн иж бүрэн үзлэгт хамруулав.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд, хүүхэд асрах “Энэрэл” төвд хивс нийлүүлж, ажиллагсдын зүгээс хүүхдүүдтэй 1 өдрийг хамт өнгөрөөв.
- ХУД-ийн ЦХ-ийн ажиллагсдыг хивсээр шагнах ажлыг уламжлал болгов.

Бусад ажлын хувьд:

- Өндөр нягттай “Богд” брендийн шинэ нэр төрлийн хивс үйлдвэрлэн гаргалаа.
- Томруулан ороох шинэ машин худалдан авч сууриууллаа.
- Шинэ машин суурилуулахад бэлтгэж 2 машиныг буулгаж газар чөлөөлөв.

2025 оны төлөвлөгөө:

- | | |
|-----------------------------|------------------|
| - Үйлдвэрлэл: | 53 000 М2 |
| - Борлуулалт : | 7 100 000 мян.₮ |
| - Хөрөнгө оруулалт: | 1 600 000 мян. ₮ |
| - Цэвэр ашиг: | 1 185 000 мян. ₮ |
| - Үйлдвэрлэлийн нэгж өртөг: | 104 000 ₮/м2 |

Ч.Энхтөр: Хэлэлцэх 2-р асуудал: Санхүүгийн 2024 оны бйадалд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлтийг ТУЗ-ийн аудитын хорооны дарга Б.Баясгалан танилцуулна.

Б.Баясгалан: Тараасан материал дээр дүгнэлт байгаа тул өөр асуулт байвал хариулъя.

Асуулт гарсангүй.

Ё.Энхтөр: 3-р асуудал буюу ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны зардал ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Батцэцэг танилцуулна.

Н.Батцэцэг: ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг ТУЗ-ийн 2-р сарын 17-ны хурлаар баталсан байгаа. Одоо хувьцаа эзэмшигчдийн хуралд батлуулахаар оруулж байна. Гишүүдийн цалин, хуралд оролцсон урамшуулал, бичиг хэргийн зардал, холбооны зардал, сургалт, аттестатчилалын зардал гээд нийт 88,022 сая ₮-ийг төлөвлөсөн байна.

Ё.Энхтөр: Хэлэлцэх асуудал дууссан тул асуулт хариулт, санал, шүүмжлэлдээ оръё.

Г.Гансүх: Эхлээд, ТУЗ-ийн даргад “Гавьяат ажилтан” болсонд баяр хүргэе! Миний асуулт: Монгол улс Евразийн холбооны гэрээнд нэгдсэн. Энэ манай компанид хэрхэн нөлөөлөх вэ? Зарим хүмүүс их дургүй байх юм.

Ц.Зоригт: Тэнд бидэнтэй төстэй хэрэглээтэй учраас зах зээл байна гэж хардаг.

Ё. Энхтөр: Манай салбарынхан ярилцаад саналаа, оны өмнө ЭЗЯ-нд өгсөн. Гэрээнд оролцох ялангуяа хүнсний салбарынхан импортын квот тогтоох тухай санал гаргасан. Дахиад хэлэлцэх гэнэлээ. Зах зээл бол байна гэж үзэж байгаа. Амьдралын өртөг ойролцоо, экспортолж байсан туршлага байгаа учир боломж бол байгаа гэж үзэж байна.

Г.Гансүх: Ашигтай байх боломжтой.

Ц.Зоригт: МУ-ын ерөнхийлөгч үйлдвэрүүдээр явсан. “Цагаан алт” хөтөлбөр хэрэгжиж байгаа. 2 их наяд ₮-ийн хөтөлбөр. Үйлдвэрүүдийн 80 % нь зээлийн хүсэлтээ өгсөн байгаа. Эргэлтийн хөрөнгийн зээл 7-8% хүүтэй байгаа. Манай компани бас оролцохоор төслөө өгсөн байгаа.

С.Мягмарсүрэн: Өнгөрсөн онд борлуулалт нилээд өссөн байтлаа цэвэр ашиг бараг хэвэндээ байх юм?

Ц.Зоригт: 2025 онд ч ашиг эрс нэмэгдэх боломжгүй. Зардлыг боломжоороо бууруулж байгаа боловч цалин, эрчим хүчний зардал байнга нэмэгдэж байна.

С.Мягмарсүрэн: Бүтээгдэхүүний үнээ нэмэгдүүлбэл яах вэ?

Ц.Зоригт: Өрсөлдөөн их байгаа. Туршлагаас харахад бүтээмж чухал. Засгийн газар цалинг байнга нэмэгдүүлэх бодлого барьдаг. Нарийн судалгаа хэрэгтэй л дээ.

С.Мягмарсүрэн: Гадаадад экспортолбол яах вэ?

Ц.Зоригт: Гадаадад гаргахад үнэ дийлэхгүй. Чанар сайн ч гэсэн гадаад дахь үнэ өрсөлдөж чаддаггүй. Хивс үйлдвэрлэхэд нарийн бичил орчин шаардлагатай.

Б.Баясгалан: Манайд орон сууц их баригдаж байгаа нөхцөлд цэвэр ноосон хивс хэрэглээ ихтэй.

С.Мягмарсүрэн: Түрээс эрэлттэй юу?

Ц.Зоригт: Энэ газар эрэлттэй.

Ц.Зоригт: Бидний хэрхэн ажилласнаас үл хамаарч өртөг их өсч байна. Харин энэ жил ноос хямдрах шинжтэй. Одоогоор хятадууд энэ жил ноос бага авах байх.

Ё.Энхтөр: ЗГ-аас зарласан ноосны урамшуулал сүүлийн жилүүдэд малчдыг дэмжсэн, бидэнд үр дүнгээ өгсөн арга хэмжээ болсон.

Хурал завсарлав.

С.Баясах : Тооллогын комиссын тогтоол №2-ыг танилцуулъя. Хэлэлцсэн 3 асуудалд хуралд оролцогчид 100 % “Зөвшөөрсөн” санал өгсөн байна.


Ё.Энхтөр: Ингээд хурал асуудлаа хэлэлцэж дууссан тул 3 асуудлаар тогтоол гарна. Эдгээрийн төслийг танилцуулъя. 3 тогтоолын төслийг уншиж сонгоё. /Тогтоолын төслүүдийг уншив./ Тогтоолуудаа батлах уу?

Оролцогчид 100% гараа өргөж батлав.

Ё.Энхтөр: Хуралд хүрэлцэн ирж оролцсон тар бүхэнд баярлалаа. Сайн сайхныг хүсье.

Хурал үүгээр 13:20 –д өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



ТУЗ-ийн нбд: Н.Батцэцэг